


Манай орны 7 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 15°C (53.6°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар +21.1°C (64.6°F) –аас +28°C (77°F), бусад нутгаар 15.1°C –аас +21°C (53.8°F –аас 64.4°F) дулаан байдаг байна.


Монгол орны хэмжээнд 7 дугаар сард ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 28 хувь нь ордог. Тус сард төвийн болон нутгийн хойд хэсгээр 80.1-140 мм, говь-цөлийн бүс нутгаар 5-40 мм бусад нутгаар 40.1-80 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 7 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр нийлбэр хур тунадасны орон зайн тархалт


2026 оны 7 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс 0.3°C-аар, ОЖД-аас 1.4°C-аар тус тус дулаан байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 6 дахь дулаан сар болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нийт нутгийн 74.4% нь дунджаас 1.1-ээс 3.4°C-аар дулаан, 25.6% нь дунджийн орчим байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 61.8 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 14.6%-иар, ОЖД-аас 6.7%-иар тус тус ахиу байсан бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 39 дэх ахиу тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 41.1% нь дунджаас бага, 44.2% нь дунджаас ахиу, 14.7% -д дунджийн орчим хур тунадас унасан байна.




Зураг 2. 2026 оны 7 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт

Монгол орны хэмжээнд болон дөрвөн бүсээр хуваан дундажлан тооцоолсон 7 дугаар сарын хоногийн агаарын дундаж температурын явцыг авч үзэхэд (Зураг 3) сарын ихэнх хугацаанд нийт нутгаар ОЖД-аас 0.2°C -ээс 8.3°C -ээр дулаан байв. Харин 1 дүгээр 10 хоногийн дунд үеэр зүүн бүс нутгаар, 2 дугаар 10 хоногт ихэнх нутгаар ОЖД-аас -0.4°C -ээс -5.6°C -ээр хүйтэн байсан байна. Хур тунадасны хувьд өмнө болон баруун бүс нутгаар хур тунадас бага орсон бол зүүн болон төвийн бүс нутгаар сарын турш харьцангуй ахиу тунадас оржээ.




Зураг3. Хоногийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Агаарын үнэмлэхүй их температур 30°C -ыг давж халсан өдөр Говь-Алтайн Тоорой, Баянхонгорын Шинэжинст сум Эхийнгол, Өмнөговийн Ханбогд, Дорноговийн Хөвсгөл, Замын-Үүд, Сайншанд орчмоор 25-29 өдөр, Өмнөговийн Сайхан, Манлай, Цогт-Овоо, Дорноговийн Эрдэнэ, Дундговийн Гурвансайхан, Говь-Алтайн Алтай, Ховдын Зэрэг, Булган, Баянхонгорын Богд, Өвөрхангайн Баруунбаян-Улаан орчмоор 20-24 өдөр, бусад нутгаар 20-оос цөөн өдөр ажиглагджээ.



Зураг 4. 30°C -аас халуун өдрийн өдрийн тооны газарзүйн тархалт

Тус сард агаарын температурын үнэмлэхүй их утга Баянхонгорын Шинэжинст сум Эхийнголд 43.2°C , үнэмлэхүй бага утга Ховд аймгийн Манхан суманд 1.3°C хүрсэн. Хөрсний температурын үнэмлэхүй их утга Сүхбаатарын Баяндэлгэр суманд 71°C , үнэмлэхүй бага утга Завхан аймгийн Цэцэн-Уул суманд -1°C хүрч хүйтэрсэн байна. Хоногт хамгийн ихдээ Хэнтий аймгийн Баян-Овоо суманд 9-ны өдөр 72.2 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 939.2гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 767.1гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Говьсүмбэрийн Чойрт 32м/с хүрчээ.



Зураг 5. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд